



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар A/72

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны 2021 оны дотоод хэрэгцээнд шаардлагатай шатахуун” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Ц.Төрмөнх

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны ерөнхий инженер

Нарийн бичгийн

дарга: Г.Хишигдэлгэр

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

О.Болд-Эрдэнэ

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Шатахууны хэлтсийн шатахууны сав, тоноглолын инженер

Б.Бат-Эрдэнэ

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

С.Үжин

“Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төв” Төрийн бус байгууллагын гишүүн

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Ц.Төрмөнх)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Хишигдэлгэр)-д даалгасугай.

ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ

